



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 2/553

Улаанбаатар хот


Цаг уур, ус судлалын хөтөлбөрүүдийн
бакалаврын оюутнуудад тэтгэлэг
олгох журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарын хүний нөөцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэх хүрээнд “Цаг уур, ус судлал хөтөлбөрүүдийн бакалаврын оюутнуудад тэтгэлэг олгох” журмыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү журмын биелэлтийг ханггуулж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газар (Л.Оюунжаргал)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газар (Ш.Цэрэндулам)-т даалгасугай.



152311603

843

Байгаль орчин, аялал жуулчлалын
сайдын 2023 оны ... дугаар сарын
...-ны өдрийн 10 дугаар
тушаалын хавсралт

Цаг уур, ус судлалын хөтөлбөрүүдийн бакалаврын
оюутнуудад тэтгэлэг олгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын боловсон хүчний нөөцийг нэмэгдүүлэх, мэргэжлийн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх, салбарын албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор МУИС-ийн Цаг уур, ус судлалын тэнхимийн цаг уур (0532210), ус судлал (0532211)-ын мэргэжлээр бакалаврын зэрэгт амжилттай суралцаж буй шилдэг оюутан, өндөр оноотой шинэ элсэгчдэд тэтгэлэг олгох үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Тэтгэлэг шалгаруулалт

2.1. Тэтгэлэг шалгаруулалтыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулсан ажлын хэсгийн хүрээнд зохион байгуулна.

2.2. Тэтгэлэг олгох сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн ахлагчаар БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газрын дарга, ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ)-ын холбогдох хэлтсийн дарга, гишүүнээр БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газар, Төрийн захиргааны удирдлагын газраас тус бүр 1 албан хаагч, Монгол улсын их сургууль (МУИС), Дархан хот дахь Хөдөө, аж ахуйн их сургууль (ХААИС)-ийн Цаг уур, ус судлалын тэнхимийн эрхлэгч нар болон холбогдох асуудал хариуцсан тус бүр 2 хүнийг оролцуулна.

2.3. Тэтгэлгийг БОАЖЯ, ЦУОШГ, МУИС, Дархан хот дахь ХААИС хамтран 10-р сард багтаан олгоно.

2.4. Тэтгэлэгт хамрагдсан оюутнуудтай гэрээ байгуулж ажиллах ба тэтгэлэгт хамрагдаж амжилттай суралцсан оюутнууд төгсөөд ус цаг уур, орчны шинжилгээний салбарт ажиллах үүрэгтэй.

Гурав. Тэтгэлэг олгох нөхцөл

3.1. Тэтгэлэгт хамрагдсан оюутнууд жилд 30 ба түүнээс дээш кредит цагийг заавал сонгон судална. Жилд олгогдох тэтгэлгийн хэмжээ 30 кредит цагийн төлбөрөөр тооцогдоно.

3.2. Оюутан суралцагчдад олгох тэтгэлэг нь дараах төрлүүдээс бүрдэнэ. Үүнд:

3.2.1. “Өндөр оноотой элсэгч”-д олгох тэтгэлэг: Шинээр элсэн орж байгаа элсэгчдээс элсэлтийн ерөнхий шалгалтад хамгийн өндөр оноо авч амжилтаараа тэргүүлсэн 2 оюутныг сонгон шалгаруулж сургалтын төлбөрийн 50%-ийн тэтгэлэг олгоно.

3.2.2. “Нийгмийн баталгааны хүрээнд тэтгэлэг олгогдож байгаа оюутан”-д олгох тэтгэлэг: Эцэг, эхийн аль нэг нь Ус цаг уур, орчны шинжилгээний салбарт 10-аас дээш жил ажилласан бол оюутанд сургалтын төлбөрийн 50%-ийн тэтгэлэг олгоно.

3.2.3. “Шилдэг оюутан”-д олгох тэтгэлэг: 2-4 дүгээр түвшний оюутнуудад сурлагын дүнгийн голч оноо 2.8 болон түүнээс дээш бол 100%, 2.80-аас 2.40 хооронд бол 75%-ийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.

3.3. Тэтгэлэг хүсэгчдийн материалыг энэ журмын хавсралтад заасан маягт болон энэхүү журмын 4.1 дэх хэсэгт заасан маягтын дагуу тухайн оны 9 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сонгон шалгаруулалтын ажлын хэсэг хүлээн авч, материал хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор ярилцлага хийнэ.

3.4. Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг хүсэлт гаргасан оюутан, суралцагчдын материалыудыг хянаж үзсэний үндсэн дээр болзол хангасан оюутан, суралцагчдыг 10 дугаар сард багтаан сонгон шалгаруулна.

Дөрөв. Бүрдүүлэх материал

4.1. Тэтгэлэгт хамрагдах хүсэлтэй оюутан, суралцагчид дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

4.1.1. Тэтгэлэгт нэр дэвшигчид маягт 1-ийн дагуу анкет, материал бүрдүүлнэ.

4.1.2. Сургуулийн тодорхойлолт (эх хувь эсвэл баталгаажуулсан хувь)

4.1.3. Цахим систем дэх дүнгийн хуудас, дүнгийн голч (баталгаажуулсан эх хувь)

4.1.4. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгийн батламж (баталгаажуулсан хувь)

4.1.5. Ус цаг уур, орчны шинжилгээний салбарт эцэг, эхийн аль нэг нь ажилладаг бол сүүлийн 10 жилийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт

4.1.6. Төрсний гэрчилгээний хуулбар

Тав. Тэтгэлгийг түдгэлзүүлэх, цуцлах

5.1. Оюутан улирлын болон жилийн чөлөө авсан тохиолдолд тэтгэлэг олголтыг түдгэлзүүлнэ.

5.2. Тэтгэлэгт хамрагдсан боловч захиргааны болон гэмт хэргийн зөрчил гаргасан, тэтгэлэгт хамрагдахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн шалтгаанаар тэтгэлгийг олгох боломжгүй нь тогтоогдсон нөхцөлд тэтгэлэг олголтыг бүрмөсөн цуцална.

Зургаа. Тэтгэлгийн санхүүжилт


- 6.1. Ус, цаг уур, орчны салбарын хүний нөөцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэх хүрээнд тэтгэлгийн санхүүжилтийг холбогдох олон улсын төсөл хөтөлбөр болон сайдын багцын төсвөөс санхүүжүүлнэ.
- 6.2. Цаг уур, ус судлал хөтөлбөрүүдийн оюутан өөр эх үүсвэрийн санхүүжилтээр сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамрагдсан бол энэхүү тэтгэлгийг давхар олгохгүй, сургалтын төлбөрийн бус бусад төрлийн тэтгэлгүүд хүртсэн бол давхар олгож болно.

----оОо----

“Цаг уур, ус судлал хөтөлбөрүүдийн
бакалаврын оюутнуудад тэтгэлэг
олгох журам”-ын хавсралт

Маягт 1

ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ



Зураг (3*4)

Ургийн овог:
Эцэг/эхийн нэр:
Өөрийн нэр:
Регистрийн дугаар:
Оюутны код:
Сургууль:
Хөтөлбөрийн нэр:
Үнэлгээний голч дүн:
Тэтгэлгийн төрөл:

Сурлага, хөдөлмөр, урлаг спорт, уралдаан тэмцээн, үзэсгэлэн, наадам, фестиваль, олимпиад, эрдэм шинжилгээний хурал, сайн дурын аян зохион байгуулсан, оюутны санаачилгатай клуб ажиллуулсан, төсөл хөтөлбөрт оролцсон байдал (сүүлийн хичээлийн жилд)

Уралдаан тэмцээний нэр	Зэрэглэл, Чансаа	Хэзээ	Хаана	Гаргасан амжилт

Өмнө нь тэтгэлэгт хамрагдсан байдал (сүүлийн хичээлийн жилд)

Тэтгэлгийн нэр	Хэзээ	Хаана	Тэтгэлгийн хэмжээ

Холбоо барих утасны дугаар: 1..... 2.....

Цахим шуудангийн хаяг:

Дээрх мэдээллийг үнэн зөв бөглөсөн: ()

(Гарын үсэг)

202.... он сар өдөр

---оо---